

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН 2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

Нийгмийн салбарын хүрээнд иргэдийн бүтээлч оролцоог өргөжүүлэх, нийгмийн үйлчилгээг иргэд тэгш авах боломжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд анхаарлаа төвлөрүүлэн Шинэчлэлийн Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Нийгмийн салбарын 10 гаруй хөтөлбөрүүдийг иргэд, олон нийтийн оролцоотойгоор хэлэлцүүлэн боловсруулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.

Нэг. Боловсролын чиглэлээр

Ерөнхий боловсролын сургуулийн сурагч, ажилтан нэг бүрийг онлайн мэдээллийн сантай болгож, 2014-2015 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын сургуульд 17842 хүүхэд суралцаж, суурь боловсролын хамран сургалт 94,1хувь, сургуулийн өмнөх боловсролд 181 багш ажиллаж, 6493 хүүхэд хамрагдаж, хамралт 86,9 хувь хүрч өмнөх оноос 3,2 хувиар өсчээ.

Нэгдсэн бодлогын хүрээнд сурагчид, багш нэг бүрийг онлайн мэдээллийн сантай болгож, 9 хувийн цэцэрлэгүүд шинээр нэмэгдэж, одоогийн байдлаар аймгийн хэмжээнд 11 хувийн цэцэрлэгт 395 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүртэх болов.

“Багшийн хөгжил” хөтөлбөрийн хүрээнд “Багш солилцоо-1, 2” арга хэмжээгээр нийт 20 багшийг хамруулж, Монтессорийн арга зүйгээр цэцэрлэгийн багш нарыг солилцуулан ажиллуулж, БНСУ-д 2 багш, нийслэлийн 23 дугаар бүрэн дунд сургуульд аймгийн төвийн Жаргалант сумын 10 багшийг солилцооны хөтөлбөрт тус тус хамрууллаа.

“Авьяас” хөтөлбөрийн хүрээнд нийт 683 дугуйлан хичээллэж, давхардсан тоогоор 17739 сурагчийг хамруулж, угсаатны бүлгүүдийн их наадмыг зохион байгуулж, уран нугаралтын чуулбар, домборын чуулга, 700 сурагчийн найрал дуу, 100 хүүхдийн хөөмий, ардын язгуур урлагийн 1805 хүүхдийн тоглолтуудыг бэлтгэн хүүхэд бүрийг хөгжүүлэх зорилтын хүрээнд зохион байгуулж, ард иргэддээ сурталчлав.

“Ном хөтөлбөр”-ийн хүрээнд хүүхдүүдийг номонд дур сонирхолтой болгох зорилгоор Монгол улсын шилдэг зохиолч, яруу найрагчдын 2 удаагийн уулзалтыг

Ерөнхий боловсролын 24 сургуулийн сурагчдын дунд зохион байгуулж, давхардсан тоогоор 20000 гаруй хүүхдийг хамруулж, Ховд телевиз, Утга зохиол сонин, Монголын үндэсний радиогийн 2 удаагийн нэвтрүүлгийг бэлтгэж иргэдэд хүргэлээ.

Аймгийн Засаг даргын санаачлагаар зохион байгуулсан “Ахмад багш нарын II зөвлөгөөн”-д 220 ахмад багш, боловсролын болон сургуулиудын удирдах ажилтан нийт 250 гаруй төлөөлөгчид оролцов.

Аймаг, сумдын албан бус боловсролын гэгээрэл төвүүдийг “Насан туршийн боловсролын төв” болгон шинэчлэн байгуулж, 30,0 сая төгрөгөөр барилгыг засварлаж, 2013-2014 оны хичээлийн жилд албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд 828 хүүхэд залуус хамрагдсанаас 260 суралцагч суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшээд байна.

2013-2014 оны хичээлийн жилд Ховд Их сургууль 35 мэргэжлээр 807 оюутан төгсгөж, хамтын ажиллагаатай АНУ-ын Мидвест их сургууль, Олон улсын боловсролын хамтын нийгэмлэг, Дэлхийн глобал удирдагчдын сантай хамтран баруун бүсэд “Боловсролын манлайлал” сэдэвт олон улсын форумыг анх удаа зохион байгуулж, “Хөгжил” политехник коллежийг 24 мэргэжлээр 519 суралцагч төгсөж, коллеж төгсөгчдийн 77 хувь нь ажлын байраар хангагдаад байна.

Боловсролын байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх, суралцагсдын суралцах, хөгжих таатай орчинг бүрдүүлэхэд анхаарч 2014 онд төсвийн болон олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар нийт 9,3 тэрбум гаруй төгрөгийн барилга байгууламж шинээр барьж, 696,1 сая төгрөгийн их засвар, 80,0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдэж, Чандмань, Дөргөн, Эрдэнэбүрэн сумдын сургуулиудад тус бүр нь 120 сая төгрөгийн үнэтэй эко ариун цэврийн байгууламжийг барьж ашиглалтанд орууллаа.

Монголын багш нарын 48 дахь өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд санаачлага гаргасан багш нарыг 18.9 сая төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

Хоёр. Соёл, спорт, аялал жуулчлалын чиглэлээр

“Галдан бошигт хаан”-ы мэндэлсний 370 жилийн ойд зориулан зохиолч, яруу найрагч Н.Сүхдоржийн зохиол “Галдан бошигт хаан” дуулалт жүжгийг Монгол

Улсын Ардын Жүжигчин Б.Мөнхдоржийн найруулгаар дэглэж, 5 удаагийн тоглолтыг амжилттай зохион байгуулж, үзэгчдээс өндөр үнэлгээ авч нийт 17000 хүнд соёл урлагийн үйлчилгээг хүргээд байна.

“Алтан өв” хөтөлбөрийн хүрээнд Булган, Дарви, Дуут, Зэрэг, Мянгад сумын соёлын өдрүүдийг зохион байгуулж, “Угсаатны бүлгүүдийн өв соёлын наадам”, “Өв соёлоороо гоёцгоо” уралдаанд нийт 2600 гаруй ардын авьяастан, хүүхэд багачуудыг хамруулж, дотоод, гадаадын жуулчдын сонирхлыг татахуйц өвөрмөц хэлбэрээр зохион байгууллаа. 13 сумын орон нутаг судлах танхимын 777 дэсийн 1574 үзмэр, аймгийн музейн 892 дэсийн 2977 ширхэг үзмэрийн тоон мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлж, 6 сумын “Алтан өв” соёл урлагийн өдрийг зохион байгуулж, олон нийтэд сурталчиллаа.

“Алтан өв” хөтөлбөрийн хүрээнд Монголын төрийн шүтээн, 1994 онд Их наран хутагтын санаачлагаар төвдийн Лхас хотод захиалгаар бүтээсэн “Алтан ганжуур” судрыг дөргөн сумын иргэд 140 тэмээгээр жин тээж Ховд аймгийн төв талбайд ёслол хүндэтгэлтэйгээр залах арга хэмжээг зохион байгууллаа.

“Алтайн дуулал” яруу найраг, богино өгүүллэгийн наадам, Айтыс тэмцээн, Үг, ая, бийрээр урлаачдын аймгийн анхдугаар зөвөлгөөнийг зохион байгуулж, УИХ-ын гишүүн Д.Дэмбэрэлийн санаачлага ивээлээр “Морин хуурын наадмыг Манхан суманд амжилттай зохион байгуулав. Уг наадамд аймгийн 17 сумын 130 гаруй морин хуурчид хамтлаг, гоцлол төрлөөр ур чадвараа уралдууллаа.

Зэрэг, Дөргөн, Дарви, Булган, Дуут сумд соёл, урлагийн өдрөө хуваарийн дагуу амжилттай зохион байгууллаа. Зэрэг, Дарви сумууд сумын 90 жилийн ойн түүхэн гэрэл зураг үзэсгэлэн, урлагийн тоглолт, Булган сум урлагийн тоглолтоо аймаг болон Улаанбаатар хотноо тавьж, Дуут сум угсаатны түүх ахуйн зан зашлаа харуулсан үзэсгэлэн, тоглолт, Дөргөн сум 100 тэмээний жингийн цуваа, алдарт Гаанжуур даанжуурын 108 ботио дээдлэн залж, угсаатны ахуйн түүх соёл уламжлалаа харуулсан үзэсгэлэн, урлагийн тоглолт зэргийг зохион байгуулж, иргэдэд үйлчиллээ.

“Аварга” хөтөлбөрийн хүрээнд 10 төрлийн спортын секц дугуйланд 500 гаруй тамирчин хамрагдаж, улсын аврага шалгаруулах тэмцээнд 17 төрлөөр оролцон 301 гаруй медаль хүртсэн амжилтыг үзүүлж, 8 дасгалжуулагч, 32

тамирчдад 10750 000 төгрөгийн урамшуулал олголоо. “Ховд-2014” бага олимпыг 17 сумын 28 багийн нийт 2000 гаруй баг тамирчдыг оролцуулан зохион байгуулан 12 төрлөөр хурд хүч, авхаалж самбаагаа сорисон нь иргэдийн биеийн тамир спортоор хичээллэх хүртээмжийг дээшлүүлсэн өргөн хүрээтэй арга хэмжээ болж, “Хөөмийн 3-р наадам”-ыг олон улсын статустайгаар өргөжүүлэн зохион байгуулж 8 орны 90 хөөмийчид ур чадвараа сорилоо.

“Мөнгөлөг шагшуурга” баруун бүсийн цас мөсний баярыг өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулж, УИХ-ын гишүүд, яамдын сайд, дэд сайд нар болон ОХУ-ын Алтайн Бүгд найрамдах улс, БНХАУ-ын ШУӨЗО-ны төлөөллүүд, зэргэлдээ аймгуудын сум, орон нутгийн 15000 гаруй иргэд оролцсон томоохон арга хэмжээ боллоо.

2014 онд Соёл спорт аялал жуулчлалын яамны хөрөнгө оруулалтаар 5 сумын соёлын төвд “Мини кинотеатр”, зөөврийн аппаратур, 8 соёлын төвд оффисийн ширээ, аймгийн нийтийн номын сан, сумдын номын санд нийт 54,6 сая төгрөгийн номын сангийн стандарт тавиур, Музейд камер, дохиололын систем, сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах 11,9 сая төгрөгийн сейф, тавилга, иж бүрэн компьютер олгов.

Өв соёлын хүрээлэнгийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Алтан өв” хөтөлбөрөөс 22,6 сая, музейн дотоод урсгал засварт Орон нутгийн хөгжлийн сангаас 3 сая, Хөгжимт драмын театрт ССАЖЯ-ны соёл урлагийг дэмжих сангаас 66 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 95 сая, Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангаас 15 сая, нийт 201,5 сая төгрөг ирдэмжлэг үзүүлсэн байна. Мөн Ерөнхийлөгчийн Тамгын газрын хөрөнгө оруулалтаар аймгийн музейд Ерөнхийлөгчийн танхимыг тохижуулан ажиллуулав.

16 сум сургуулийн номын санчдыг соёл урлагийн байгууллагын тайлангийн программын сургалтанд хамруулж, вэйб лавлагаа, номын сангийн тайлан, автомажуулалт, тооллого, бүрдүүлэлт, захиалгын талаарх мэдлэгийг эзэмшүүлэв.

Музейн ажилтнуудын чадавхижуулах сургалтыг Монголын үндэсний түүхийн музейтэй хамтран зохион байгуулж, Соёл урлагийн байгууллагын удирдах ажилтнуудын сургалтыг соёлын салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүд, Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтууд, харъяа яамны

тушаал шийдвэрийг нэгж дээр чанартай хэрэгжүүлэх, соёлын хүртээмж, чанар, үр ашгийг хэмжих үзүүлэлтийг тооцох арга зүй, байгууллагынхаа үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох талаар мэдэээллүүд өглөө.

Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх зорилгоор Соёл урлагийн их сургуультай сүүлийн 3 жил дараалан хамтран ажиллаж, элсэн суралцуулах элсэлтийг зохион байгуулж одоогийн байдлаар манай аймгаас дуулаач, хөгжим, бүжиг, жүжиг, концертмейстр, соёлын менежмент зэрэг ангиудад 50 гаруй оюутан суралцуулж, Соёл, урлагийн их сургуульд Концертмейстер, найрал дуу, хөгжмийн багш, менежмент зэрэг ангиудад 11 хүүхдийг, 9 мэргэжлээр 11 оюутан тус тус элсүүлэн суралцуулж байна. Хөгжимт драмын театрын 1 хөөмийч, 2 уртын дуучныг бакалаврын сургалтанд хамруулан төгсөв. Бүх шатны соёлын байгууллагын мэргэжилтэй боловсон хүчний хангалт 56.5 хувьд хүрч өмнөх оныхоос 4 хувиар нэмэгдлээ.

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр

Аймгийн эрүүл мэндийн бодлогыг эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйл, өвчлөл эндэгдлийг тууштай бууруулан, хүн амын цэвэр өсөлтийг ханган, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амд тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлж, стандартад нийцсэн оношлогоо, эмчилгээ, үйлчилгээ авах боломжийг иргэн бүрд олгоход чиглүүлж ажиллаа.

Тус онд Засгийн газрын тогтоол, Эрүүл мэндийн яамнаас баталсан 10 үндэсний хөтөлбөрийн 32 заалтуудыг хяналтандаа авч гүйцэтгэлийг тооцож, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай мэдээллийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн аймгийн “Нэг эрүүл мэнд” салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, Шинэчлэлийн Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор орон нутагт Эрүүл мэндийн салбарын 5 хөтөлбөрийг иргэд, олон нийтийн оролцоотойгоор хэлэлцүүлэн боловсруулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.

2014 онд Ховд аймгийн хүн амын дундаж наслалт 71.1 болж улс, аймгуудын түвшнээс дээгүүр буй нь хүн ам зүйн бодлого зохих түвшинд байгааг харуулж байна.

“Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих” жилийн ажлын хүрээнд үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, төлөвлөн хэрэгжүүлэх, хяналт тавих ажлын хэсгийн аймгийн Засаг даргын А/41 тоот захирамжаар томилон ажиллуулж нийт 8 зорилт, 45 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөө гарган хэрэгжүүлж 70 хувийн биелэлттэй байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулахад удирдлагын оролцоог дээшлүүлэх зорилгоор бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга, Эрүүл мэндийн төвүүдийн дарга нийт 160 хүн оролцсон “Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулахад дэмжлэгт удирдлагуудын оролцоо” аймгийн зөвлөгөөн, сувилахуйн дунд мэргэжилтнүүдийг чадавхижуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн “Эх хүүхдийн эндэгдлийг бууруулахад сувилахуйн тусламж үйлчилгээг сайжруулах нь” аймгийн зөвлөгөөн, “Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад багийн эмчийн оролцоо” бүсийн зөвлөлдөх уулзалтуудыг тус тус зохион байгуулснаар эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулахад орон нутгийн салбар хоорондын үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ болж, зөвлөгөөн, зөвлөлдөх уулзалтуудаас зөвлөмж, Засаг даргын албан даалгавар, “Эх хүүхдэд ээлтэй сум”-ын болзол зэргийг боловсруулан хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Мөн шатлалын эмнэлэг бүрт “Эх нярайн эрүүл мэнд”, “Эсэн мэнд амаржихуй”, “Хүүхдийн эсэн мэнд амьдрахуй” үндэсний стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор амйгийн засаг даргын 12 тоот албан даалгаварыг гаргаж хүргүүлээ. Сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга, эмчлэгч эмч, багийн эмч нарт “Хүүхдийн өвчний цогц менежмент” хөтөлбөрийн сургалтанд бүрэн хамруулж удирдамжийг мөрдүүлж ажиллаа.

Эдгээрийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд Ховд аймагт эхийн эндэгдэл 1990 онд 100 000 амьд төрөлтөнд 366.7 промил байсан бол 2014 онд 86.7 промил байгаа нь 1990 онтой харьцуулахад 4 дахин, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 онд 1000 амьд төрөлтөнд 98 промил байсан бол 2014 онд 24.1 промил болж 4 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Гэвч эх, хүүхдийн эндэгдэл баруун бүсэд өндөр байсаар байгаа нь бид бүхний анхааралд зайлшгүй байх нэн тэргүүний асуудал болж байна.

2014 онд Эрүүл мэндийн яамнаас эрх нь шилжиж ирсэн Буянт сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажлыг “Авга ач нар” компани 223,3 сая төгрөгөөр гүйцэтгэж, улсын комисст хүлээлгэн өгч, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд аймгуудаас анх удаа Вирус судлалын лабораторийг Дэлхийн банкны 140 сая төгрөгийн санхүүжилтээр шинээр байгуулж ажиллуулснаар вирусын сорьцыг Улаанбаатар хот руу тээвэрлэхгүйгээр орон нутагтаа тодорхойлох боломж бүрдэж зөвхөн сүүлийн 7 хоногт БОЭТ, сум, өрхийн эмнэлгүүдээс 40 сорьц хүлээн авч томуу, томуугаас бусад амьсгалын цочмог халдвар үүсгэгчийг илрүүлэх шинжилгээ хийгээд байна.

Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар Чандмань сумын яаралтай тусламжийн машин, БОЭТ-д 200 гаруй сая төгрөгийн эх хүүхдийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг олгож, Монгол, Белгийн Засгийн газрын чадавхижуулах төслийн гэрээг батлуулсан нь иргэдийн төрөлжсөн, нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ авах боломж нөхцлийг дээшлүүлэхэд чухал үр дүнтэй ажил болно гэж үзэж байна.

Өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, зөв дадал хэвшилтэй болгох зорилготой “Эрүүл мэндийн довтолгоо” арга хэмжээг аймгийн 26541 өрхөд хүргэж 31152 иргэнийг мэдээлэл, сурталчилгаанд хамруулсан нь иргэдийн эрүүл мэнддээ хяналт тавих, эрт эмчилгээ, оношлогоонд хамрагдахад чухал үр дүнгээ өгсөн арга хэмжээ болж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдлоос хамгаалахад чиглэгдсэн “Эрүүл гудамж – Миний хашаанаас” аяныг Жаргалант сумын Цамбагарав, Буянт, Бичигт багуудад зохион байгуулж, тус багуудын нийт өрхийн 97 хувь нь хашааны хаалгаа бүрэн хээлж, дугаарлаж, хаягжуулсан, 72 хувь нь хашаагаа будаж, шохойдон өнгөлж, 40 хувь нь стандартын шаардлага хангасан бие засах газар, бохирын цооногтой болж, засч тэгшлэх шаардлагатай гудамжны 75 хувийг тэгшилж засаад байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдлын талаар хэлэлцүүлж жил бүрийн орон нутгийн хөгжлийн сангаас 30 сая, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн 3-аас доошгүй хувийг иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх, сөрөг үр дагаврыг бууруулах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулж байхаар тогтоол гаргасан нь иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэхэд ихээхэн дэмжлэг болно гэж үзэж байна.

Гамшиг, эрсдлийн менежментийг сайжруулах сургалтыг эрүүл мэндийн төвийн удирдлагуудад нэг удаа явуулж, малаас хүнд халдварлах болон халдварт өвчний эрсдэл, гамшигийн үеийн мэдлэг хандлага, дадлын бэлэн байдлыг хангах зорилготой Алтай, Булган Үенч сумдад мэргэжлийн анги, агентлагуудын 180 гаруй хүнийг оролцуулсан “Нэг эрүүл мэнд” үзүүлэх сургуулийг зохион байгуулж орон нутгаас 1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, гамшгийн үзүүлэх сургуулийг улсын онцгой байдлын газартай хамтран 4 хоног мэргэжлийн анги бүрэлдэхүүнийг оролцуулан зохион байгуулж 95.4 хувийн үнэлгээтэй шалгагдлаа. Аймгийн “Нэг эрүүл мэнд” салбар зөвлөлөөр Эбола вирусын халдвараас сэргийлэх арга хэмжээний талаар хэлэлцэж, хил гаалиар шинжилгээ хийлгэх шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн судалгааг яаманд хүргүүлж, сумдад халдвараас урьдчилан сэргийлэх аргачлал, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар албан тоотыг хүргүүллээ. БОЭТ-д болзошгүй халдварын үед шаардагдах эм, урвалж бодис, оношлуур, био бэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, эмнэлгийн багаж хэрэгсэл сорьц цуглуулах хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна.

Сум, өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгийн усан хангамж, ариун цэврийн нөхцлийг сайжруулахад анхаарч Ховд аймгийн Жаргалан өрхийн эрүүл мэндийн төв, Алтай, Мянгад, Зэрэг, Манхан, Буянт сумын Эрүүл мэндийн төвүүдийг цэвэр бохир усны сүлжээнд холбогдов. Эрүүл мэндийн төвүүдийн эмчлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийг зардал нэг бүрээр тооцон Эрүүл мэндийн яаманд хүргүүлж өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилтэнд орон нутгийн хөгжлийн сангаас 60 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүллээ.

Эрүүл мэндийн салбарт орон нутгийн хөгжлийн сангаас 5 хөтөлбөр, төслийн арга хэмжээнд 140.6 сая төгрөгийн санхүүжилтээр бүх сумдыг ургийн доплер, пульсоксиметрээр хангаж, 9 суманд зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, 8 сумын эрүүл мэндийн төвд гал тогооны цахилгаан иж бүрэн тоног төхөөрөмж, бусад нэн шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангаж, эмч мэргэжилтнүүдийг сургаж дадлагжуулах, БОЭТ-ийн цахим үйлчилгээг өргөжүүлж, Амаржих газрын төрөх, нярайн өрөөнүүдийн халаалтын асуудлыг шийдвэрлэн, аймгийн Нийгмийн хөгжлийн хэлтсээс санаачлан “Нийгмийн эрүүл мэндийн үзлэг, сургалт сурталчилгааны цогц арга хэмжээ”-г 8 сумын 16 багийн иргэдэд хүргэж, 5375 хүнд нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношилгоо хийж,

эрүүл мэндийн боловсрол олгох сургалтанд 2392 хүнийг хамруулсан нь салбарын өмнө тулгамдсан нилээдгүй асуудлуудыг шийдвэрлэхэд үр дүнгээ өгч, хүндээ хүрсэн ээлтэй арга хэмжээ боллоо.

Тус онд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр БОЭТ, Булганы нэгдсэн эмнэлэг, Мөстийн сум дундын эмнэлгүүдэд 4 321 928.1, хувийн хэвшлийн ор бүхий 5 эмнэлгүүдэд 448 600.0, сумдын болон хувийн эмийн сангуудад 252 000.0, нийт 5 022 528.1 төгрөгийг олгосон нь иргэдийн эмийн болон асаргаа, сувилгааны зардлыг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр шийдвэрлэх санхүүжилт өмнөх оныхоос 2.5 дахин өслөө.

Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох салбар зөвлөлийг аймгийн Засаг даргын захирамжаар шинэчлэн батлуулж шинээр үүдэн эмнэлэг 3, шүдний хувийн эмнэлэг 2, эмийн сан 2-оор тус тус нэмэгдэж үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй "Мөнхцохилохуй" зүрх судасны эмнэлэг нь 4 давхар шинэ байртай болж, "Ач заяа" хувийн эмнэлэг нь эмнэлгээ өргөтгөснөөр төр хувийн хэвшлийн түншлэлийн харилцаа өргөжин хөгжиж байна.

2014 онд өрхийн Эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн хүрэлцээгүй байдалд анхаарч аймгийн Засаг даргын нөөцөөс тус бүр 5 сая, Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангаас тус бүр 7 сая төгрөг, нийт 60 сая төгрөг олгосон нь өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг болж чадлаа.

Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчийн төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтыг төрөөс санхүүжүүлэх журмын дагуу 2014 онд 17 эмч мэргэжилтнийг хамруулж, хувийн болон байгууллагын зардлаар ариутгалын сувилагч 2, гемодиализын сувилагч 1, их эмч 2 –ыг тус тус суралцуулж, Солонгос улсад төрийн санхүүжилтээр нярайн эмч яаралтай тусламжийн эмчийг 3 сарын, мэс заслын эмчийг ОХУ-д 1 сарын мэргэжил дээшлүүлэх сургалтанд, "Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил"-ийн ажлын төлөвлөгөөний дагуу 8 эмч, 16 сувилагчийг сэлгэн ажиллуулах ажлын байранд дагалдуулан сургах сургалтыг зохион байгуулав.

Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн хэрэгцээг тооцож, давтан сургалтын төлөвлөгөөг боловсруулж, сумдын эрүүл мэндийн

төвүүдэд 2-оос дээш их эмч, Булган сумын Нэгдсэн эмнэлэгт 12 их эмч, Мөст сум дундын эмнэлэг, Манхан сумын эрүүл мэндийн төвд тус бүр 4 их эмч ажиллаж төрөлжсөн мэргэжил эзэмшсэн их эмчийн тоо жилээс жилд нэмэгдэж байна.

2014 онд БОЭТ болон сумдын ЭМТ-ийн стационарт хэрэглэгдэх 617.3 сая төгрөгийн эмийн тендэрт 15 эм ханган нийлүүлэх байгууллага шалгарч чанартай, үйлчилгээний өндөр идэвхитэй эмийг оны эхнээс нийлүүлж, нийт эмийн 74.6 хувийг тендэрээр хангах арга хэмжээг зохион байгууллаа. Эмийн сангуудын үйл ажиллагааны стандартын байдалд 3 удаа хяналт үнэлгээ хийж холбогдох заавар зөвлөмжийг хүргүүлж, зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь сумдад 75, аймгийн төвд 84 хувьд хүргээд байна. “Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх нь” хөтөлбөрийг боловсруулан батлуулж, “Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх” баруун бүсийн эмч мэргэжилтнүүдийн зөвлөгөөн, “Нянгийн эсрэг эмийн зохиостой хэрэглээг хэвшүүлцгээе” сургалтыг аймгийн их эмч, эм зүйч, багийн бага эмч нарыг хамруулан зохион байгуулж Монос групптэй хамтран “Эрүүл мэндийн боловсрол-2014” аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж, сумдын эм зүйч, эмийн сангийн эрхлэгч, эрүүл мэндийн төвийн дарга нарт эмийн зохистой хэрэглээ, сүүлийн үеийн өндөр идэвхитэй эмүүдийн мэдээллээр 2 өдрийн сургалт хэлэлцүүлэг зохион байгууллаа.

2014 онд нийт 420825 хүнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, 23899 хүнийг хэвтүүлэн эмчилж, 2306 эхийг эсэн мэнд амаржуулж, 2320 нярай эсэн мэнд бойжиж, халдварт өвчний 453 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн жилийн мөн үеийнхээс эрүүл мэндийн үзлэг 4517, хэвтүүлэн эмчилсэн хүний тоо 879 тохиолдлоор тус тус өсч, төрөлт 58, халдварт өвчин 256 тохиолдлоор тус тус буурсан байна.

Америкийн Virtue Fandutoin сангийн нүдний эмч нар 532 иргэдэд үзлэг хийж, нүдний мэс заслын хагалгааг 145 хүнд, Францын түлэнхийн мэс заслын эмч нар 60 хүнд үзлэг хийж 6 хүнд түлэнхийн хагалгаа, Австралийн эмэгтэйчүүдийн дурангийн эмч нар аймагт үзлэг хийж эмч мэргэжилтэнд сургалт хийж дурангийн 2 хагалгааг орон нутагт хийлээ.

Эрүүл мэндийн сайдын 183 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий хорооны бүрэлдэхүүнийг Засаг даргын А/361 тоот захирамжаар байгуулан эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээг орон нутагт зохион байгуулах ажлын

төлөвлөгөө, үзлэгт хамруулах графикийг боловсруулан батлуулж ажиллуулж, “Хавдрын эсрэг үндэсний аян-2014”-ний хүрээнд 1672 хүнийг хавдрын үзлэг оношлогоонд хамруулж шаардлагатай иргэдийг хяналтандаа авч эмчилгээ оношлогооны асуудлыг шийдвэрлэн БОЭТ-д “Итгэл хавдаргүй Монгол” үндэсний сангаас хавдрын хөнгөвчлөх эмчилгээний 2 өрөөг 4 ор бүхий 13.6 сая төгрөгийн 25 нэр төрлийн тоног төхөөрөмж багаж хэрэгсэлтэйгээр тохижуулан ажилд орууллаа.

БОЭТ-д энэ оны мөн үеийн байдлаар 9986 хүн хэвтэн эмчлүүлсний 638 буюу 6.4 хувийг өөр аймгаас хэвтэн эмчлүүлэгчид эзэлж, эмнэлгийн заалтаар Улаанбаатар хотод 439 хүн эмчлүүлсэн нь өнгөрсөн мөн үеийнхээс 62 буюу 12.3 хувиар буурч сумаас иргэдийг урьдчилан цахим бүртгэлд хамруулж хүлээгдэлгүй үйлчлэх журмыг мөрдүүлэн ажиллаж байна.

2015 онд эрүүл мэндийн салбарт орон нутгаас тодорхой дэмжлэг үзүүлэн ажиллах болно. Тухайлбал. 2015 онд Эрүүл мэндийн салбар үүсч хөгжсөний 90 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан БОЭТ-ийн орчмын зам талбай, гудамж, орчныг тохижуулахад 150 сая, дээврийн засварт 50 сая, алсын яаралтай тусламжийн машин шинэчлэхэд 50 сая, Зооноз өвчин судлалын төвийн машин шинэчлэхэд 25 сая, гамшгийн үеийн эбола вирусын халдвараас хамгаалах 30 хувцас авахад 3.5 сая, багийн эмчийн унааг шинэчлэхэд 40 сая, хөтөлбөр төслийн арга хэмжээг санхүүжүүлэхэд 40 сая нийт 358.5 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангаас олгохоор төсөв, төлөвлөгөөнд тусган батлууллаа.

Мөн БОЭТ-ийг Монгол Бельгийн Засгийн газрын чадавхижуулах төсөлд хамруулж Монгол талаас санхүүжих 8.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт суулгаж 1 тэрбум төгрөгийг 2015 оны төсөвт тусган шийдвэрлүүллээ.

Эрүүл мэндийн сайдын багцаас зарим эрүүл мэндийн төвийн барилгын засвар, БОЭТ болон сумдын Эрүүл мэндийн төвийн яаралтай тусламжийн машиныг шинэчлэх талаар тодорхой хөрөнгө оруулалтуудыг шийдвэрлүүлэхээр санал хүргүүлээд байна.

Дөрөв. Хөдөлмөр эрхлэлт, Нийгмийн хамгааллын чиглэлээр

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламж, үйлчилгээнд хамрагдах 17509 иргэдэд 7,6 тэрбум төгрөг зарцуулж, 268 ахмад настанг амраан сувилж, 2590 ахмадад 499.7 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлт үзүүлээд байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 88 зорилтот бүлгийн 194 амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой

иргэдэд үзүүлж, амьдрах ухааны зөвлөгөө, мэдээллээр хангаж ажлын байртай болоход нь 75.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

Хүнс тэжээлийн хомсдолтой 246 өрхийн 1610 иргэнийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж, 130,0 сая төгрөгийн хүнсний талон олгож, “Орлогыг орлуулан тооцох арга”-аар өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд 18639 өрх хамрагдаж, салбар дундын мэдээллийн санг үүсгэж, аймаг, сум, багийн түвшинд өрх, хүн амын талаар 138 төрлийн мэдээллийг тусгай болон энгийн хэрэглэгчийн түвшинд бодлого, төлөвлөлтөнд ашиглах боломжтой боллоо.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, эрхийг нь хамгаалах олон улсын конвенцийн хэрэгжилтийг орон нутагт хэрэгжүүлэх, тэдний бодит оролцоог нэмэгдүүлэх, шинэ хандлага бий болгох, нийгмийн амьдралд татан оролцуулах, нийгэмшүүлэх зорилгоор “Нэг байгууллага - нэг иргэн” аяныг зарласнаар 30 байгууллага, 30 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сэтгэл зүйн болон санхүүгийн туслалцаа үзүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалт, сувиллын төвийн үйл ажиллагаанд 16,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж 40 гаруй хүүхдийг нөхөн сэргээх, тусламж үйлчилгээнд хамруулж, иргэдэд ээлтэй дэд бүтэцтэй 50 байгууллага, аж ахуйн нэгж шинээр бий болж, Жаргалант сумын 610 ахмад, хөгжлийн бэрхшээлтэй 150 гаруй иргэн нийтийн тээврээр хөнгөлөлттэй зорчжээ.

2014 оны “Гэр бүлийн хөгжлийг дэмжих” жилийн хүрээнд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” хэлэлцүүлэг, “Насанд хүрээгүйчүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” аймгийн зөвлөгөөн, 17 суманд “Гэр бүлийн үнэ цэнэ” сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 2500 гаруй эцэг эхчүүд, хүүхдүүдийг хамруулж, гарсан санал санаачлагаас үүдэн аймгийн Засаг даргын захирамжаар сар бүрийн 2 дахь долоо хоногийн “Бямба гараг”-ийг “Гэр бүлийн өдөр” болгон төрөлжсөн арга хэмжээг зохион байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Цагдаагийн дэргэдэх “Хүүхэд, гэр бүлд зөвлөгөө өгөх төв”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор хяналт үнэлгээ хийж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж Цагдаагийн газрын дэргэд “Хамгаалах байр” нэртэйгээр гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг түр байршуулж, ахуйн зардлыг Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн хөтөлбөрөөс гаргах, хохирогчдод үзүүлэх сэтгэл зүйн болон нийгмийн үйлчилгээг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дэргэдэх “Хамтарсан баг”-аар 22 иргэнд хүргээд байна.

Бүтэн өнчин хүүхдийн судалгааг 17 сумдаас авч нэгтгэн 140 хүүхдийг тэтгэлэгт хамруулж, хүүхэд бүрт сар бүр 10.000 төгрөгний тэтгэмж олгох батламж гардуулан, хүүхэд 18 нас хүрсэн тохиолдолд дэвтэрээ авч тэтгэлэгийн мөнгөө зарцуулах эрх үүсэхээр банктэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Баруун бүсийн хүүхдийн соёлын наадам, зөвлөлгөөнийг 180 гаруй төлөөлөлтэйгөөр зохион байгуулснаар бүс нутгийн хэмжээнд хүүхдийн өмнө тулгамдаж буй асуудлуудыг Хүүхдийн төлөө үндэсний газарт хүргүүлэн, аймгуудын Засаг дарга нар хүүхдийн өмнө хүлээх үүрэг амлалт авлаа.

Нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, даатгалын үйлчилгээг чанартай хүргэх, хамрагдалтыг өргөтгөх, сангийн бие даасан байдлыг хангах зорилгоор даатгалын үйлчилгээг нэг цэгээс үзүүлж, 12360 иргэдийг тэтгэвэр, тэтгэмжид хамруулж, 26,3 тэрбум төгрөг зарцуулж, 683 ажил олгогчийн 16460 даатгуулагч заавал даатгалд хамрагдаж, шимтгэлийн орлогод 14,9 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр нийт 1118 ажил олгогчоос 2264 ажлын байрны захиалга авч, 1918 иргэнийг ажлын байранд зуучлан, “Ажилтай орлоготой Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд 7 дэд хөтөлбөр, 1 төсөл хэрэгжүүлснээр шинээр 1978 ажлын байр бий болсны 1224 нь байнгын ажлын байр 1337 бүртгэлтэй ажилгүй иргэд байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 9,7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөрийн насны 1100 гаруй ажилгүй иргэдийг бүртгэж, нийт 75 ажил олгогч 642 иргэнтэй дөрвөлсөн гэрээ байгуулж, 451 иргэн суралцаж, онолын болон дадлагын хичээлийн явцад тогтмол хяналт тавьж, ажил олгогчидтой хамтран ажилласнаар төгсөгчдийн 90 хувь нь ажлын байраар хангагджээ.

Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээний хүрээнд бүртгэлтэй ажилгүйчүүдээс нийт 133 иргэнийг мэргэжлийн түр сургалтанд хамруулан сургаж, санхүүгийн дэмжлэг олгосноор 55 иргэн байнгын ажлын байртай болов.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 7 сумын 40 малчин залуучуудыг хамруулан мал худалдан авч өгч, 40 иргэнийг аж ахуй эрхлэлтийг хөгжүүлэх хөтөлбөрт хамруулан 34,0 сая төгрөг, ХБИ-ий хөдөлмөр эрхлэлтийг

дэмжих хөтөлбөрийн хүрээнд 36 иргэнд 30,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, ажил олоход бэрхшээлтэй 40-өөс дээш насны 57 иргэнийг түр ажлын байраар хангаж, 25 иргэнийг төмс, хүнсний ногоо тариулах ажилд оролцуулж 32,2 сая төгрөгийн цалин олгож, өрхийн амьжиргаанд нь дэмжлэг үзүүлээ.

“Сум хөгжүүлэх сан”-гийн хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтөөс нийт 63 төсөлд 478,9 сая төгрөгийн дэмжлэг олгож, 109 ажлын байр шинээр бий болж, ЖДҮХСангаас манай аймагт 1.0 тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэр хуваарилагдснаас 6 тэр бум 300 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл хүссэн 114 төсөл хүлээн авч, төслүүдийг нэг бүрчлэн судлаж, иргэдээр өөрсдөөр нь хамгаалуулж, нээлттэй хэлэлцүүлэн, аймгийн нэн тэргүүнд хөгжүүлэх үйлдвэрлэлийн чиглэлд багтсан 26 төсөлд 1.0 тэр бум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгохоор шийдвэрлэснээс одоогийн байдлаар 16 аж ахуйн нэгж, иргэн 400 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл аваад байна.

Мон Эн Ко, Моннис компаниас 225 ажлын байрны захиалга авч, ажил хайгч иргэдэд танилцуулах уулзалтуудыг хөдөөгийн 2 сум, аймгийн төвд зохион байгуулснаар 191 ажлын байранд орон нутгийн иргэдийг зуучилсан байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ

МЭРГЭЖИЛТЭН

С.ДОРЖ